


ERP СИСТЕМИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН МОДУЛЬ

БАРААНЫ КАТАЛОГ ҮҮСГЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

Сургалт, дэмжлэгийн баг


БАРААНЫ КАТАЛОГ ҮҮСГЭХ ЗААВАРЧИЛГАА

1. **Odoo.erdenetmc.mn** домэйн хаягаар орж Email хэсэгт ажлын мэйл хаягаа бичээд Паспорт хэсэгт бүртгэлийн дугаараа хийж нэвтэрч орно.



Зураг 1. Хэрэглэгчийн нэвтрэх хэсэг

2. Нэвтэрч орсны дараа Odoo ERP системийн модулиуд харагдах бөгөөд **Худалдан авалт** гэсэн модулийг сонгож орно.



Зураг 2. Худалдан авалтын модуль




Мэдээлэл: Худалдан авалтын модулиар үйлдвэрийн газрын барааны каталогт бараа нэмэх, үүссэн каталогаас барааны захиалга хийх, барааны захиалгын хяналт баталгаажуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөлт, тендер

шалгаруулалт, гэрээ байгуулах, нийлүүлэлт, чанарын хяналт болон бараа хүлээн авалтын үйл ажиллагаануудын бүртгэл, хяналт хийгдэнэ.


3. Ер нь бараа оруулахад хамгийн чухал анхаарах зүйл бол барааны ангиллыг зөв олж оруулах асуудал юм.

UNSPSC ангилал нь 4 түвшинт 8 оронтой кодоор ангилсан бүлгүүдэд хуваагдсан байх бөгөөд UNSPSC ангиллыг ашиглахад зориулж Англи, Англи-Монгол, Англи-Орос, Англи-Монгол-Орос гэсэн сонголтыг дэлхийн бөмбөрцгийн зураг дээр дарж тохируулан ашиглах боломжтой.




Зураг 3. UNSPSC ангиллыг хэл сонгож харах

Өөрийн бүртгэх барааны ангиллыг олохын тулд ангиллын жагсаалтад хайлтыг орос, монгол, англи хэлээр хийх боломжийг бүрдүүлсэн. Хэрэглэгч өөрийн бүртгэх барааг тодорхойлох түлхүүр үгээр хайлт хийх нь оновчтой юм.




Зураг 4. UNSPSC ангилалд хайлт хийх

- Хэрэглэгчийн эрх, үүрэгтэй холбоотой цэсүүд харагдах бөгөөд каталогт барааг шинээр бүртгэх хүсэлтийг **Бараа** цэсийн **Шинэ бараа бүртгэх хүсэлт** дэд цэсээр орж бүртгэнэ.




Зураг 5. Шинэ бараа бүртгэх хүсэлт оруулах



Зураг 6. Хэрэглэгчийн ажиллах товчны тайлбар

Шинэ бараа бүртгэх хүсэлтийн холбогдох талбаруудын мэдээллийг оруулж хадгалах товч дарж хадгална. Энэ үед тухайн шинэ барааны хүсэлт нь **Ноорог** төлөвт байна.





Зураг 7. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн ерөнхий мэдээллийн цонх.

Заавал оруулах талбарууд улаанаар харагдаж байна.

5. Барааны **ерөнхий мэдээлэл**д дараах мэдээллүүд агуулагдана. Үүнд:

- Нэр барааны нэр+ брэнд+модель
- *UNSPSC ангилал*: тухайн барааны ангиллын код, нэрийг зөв сонгох
- *Гарал үүсэл*: Барааны гарал үүсэл үйлдвэрлэгч улсыг оруулна.
- *Брэнд*: тухайн барааны брэндийг байвал сонгоно, байхгүй бол Create товчийг дарж үүсгэж өгнө.
- *Загвар*: тухайн барааны загварыг байвал сонгоно, байхгүй бол Create товчийг дарж үүсгэж өгнө.
- *Хэмжих нэгж*: Хэмжих нэгжээс сонгоно.
- *Эдийн дугаар*: Санхүүгийн бүртгэлийн дугаар /жишээ нь: 8586167300000-6520/
- *ERA Ангилал*: Санхүүгийн ERA Financials системд бүртгэн ашиглаж буй барааны ангиллыг сонгож болно. Эдийн дугаар оруулсан үед ангилал өөрөө татагдаж орж ирнэ.
- *Үйлдвэрлэгчийн код*: тухайн барааны үйлдвэрлэгчээс олгосон барааны кодыг оруулж болно.
- *Хөрөнгийн төрөл*: тухайн барааг үндсэн хөрөнгө эсвэл эргэлтийн хөрөнгө болохыг сонгоно.
- *Бар код*: Шаардлагатай бол оруулж болно.
- *Төсвийн үнэ*: Тухайн барааны үнийг оруулж болно.
- *Шошго*: оруулсан барааны тухай нэмэлт тэмдэглэгээ дараа бараа хайх үед ашиглана.
- *Хавсралтууд*: Тухайн бараатай холбоотой нэмэлт материал хавсаргах шаардлагатай бол хавсаргаж болно.
- *Нэмэлт тайлбар*: Тухайн барааны талаар нэмэлт тайлбар оруулах шаардлагатай бол оруулж болно.

 **Анхааруулга**: Нэр барааны нэр оруулж хадгалаад дахин өөрчлөх бол нэр+ брэнд+модель дахин өөрөө үүсэхгүй тул заавал гараар засна.

 **Анхааруулга**: Хэрэглэгч та Эдийн дугаарыг оруулахад барааны ERA ангилал өөрөө сонгогдон гарч ирэх боломжтой. Хэрэв эдийн дугаар аваагүй шинэ бараа бол тухайн бараа аль ангилалд байхыг сонгож оруулна.

6. Шинэ бараа үүсгэх явцад тухайн барааны техникийн үзүүлэлтийг оруулахдаа Техникийн үзүүлэлт цонх дээр **нэмэх** товч дарж оруулна.

Linear actuator FESTO DFPI MN

Ижил төстэй бүтээгдэхүүнийг харьцуул

Ерөнхий мэдээлэл Техникийн үзүүлэлт

+ Нэмэх Сонгох

Нэр	Утга	Хэмжих нэгж	Нөхцөл	Үзүүлэлтийн төрөл
Загвар /Модель/ [нэгж]	DFPI-200-250-ND2P-E-NB3P	нэгж	Тэнцүү	Санал болгож байна
Гүйцэтгэх механизмын цилиндрийн диаметр [мм]	200	мм	Тэнцүү	Статик

Зураг 8. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн техникийн үзүүлэлт оруулах цонх


Техникийн үзүүлэлт нь UNSPSC ангилалтай холбоотой тул шинэ бараа бүртгэх хүсэлт оруулахдаа UNSPSC ангиллыг зөв сонгох хэрэгтэй. Сонгосон UNSPSC ангиллын үндсэн ангилалд чиглэл хариуцсан бүтцийн нэгжээс оруулсан техникийн ерөнхий үзүүлэлт орсон бол дэд ангилалд тус техникийн үзүүлэлтүүд автоматаар татагдан орж ирнэ. Эдгээр техникийн үзүүлэлтүүд үзүүлэлтийн төрөл баганад **Шаардлагатай, Санал болгох, Шаардахгүй** гэсэн төлөвтэй харагдана.

- **Шаардлагатай** - төлөв нь захиалагч шинэ барааны хүсэлт илгээхдээ энэ үзүүлэлтийн утгыг заавал бөглөх ёстой ба устгах боломжгүй байна.
- **Санал болгох** - төлөв нь тухайн захиалагч үзүүлэлт дээр оруулж ч болно оруулахгүй ч байж ч болно
- **Шаардахгүй** - төлөв нь захиалагч утга оруулахгүй байж болно.
- **Статик** -төрөл нь зөвхөн тухайн бараан дээрээ хадгалагдана.

Анхааруулга: Хэрэглэгч та хэмжих хязгаар 0-100 техникийн үзүүлэлтийг

хэмжих доод хязгаар	0
хэмжих дээд хязгаар	100

гэж дээд доод утга болгон оруулна.



Зураг 9. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн техникийн үзүүлэлт оруулах цонх


- **Техникийн үзүүлэлтийг** нэмэх болон хянаж, засварлахдаа **Засварлах** товч дээр дарах бөгөөд гарч ирсэн цонхонд дараах мэдээллүүд агуулагдана.




Зураг 10. Техникийн үзүүлэлтийн цонх. Хулганаар дарж шаардлагатай байрлалд чирч байрлуулна.


Үүнд:

- *Нэр*: тухайн техникийн үзүүлэлтийн нэр
 - *UNSPSC Category*: тухайн барааны ангиллын код, нэр.
 - *UoM*: хэмжих нэгж
 - *Sequence*: тухайн барааны техникийн үзүүлэлтүүд дотроос тухайн үзүүлэлт нь хэддүгээрт эрэмбэлэгдэн байрших дараалал
 - *Дэлгэрэнгүй*: тухайн үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүй тайлбар бичиж болно.
 - *Leading /Тэргүүлж байна/*: тухайн үзүүлэлт захиалагчийн оруулсан утгатай хэрхэн жишигдэх нөхцөлийг заах төрөл байна. Үүнд: Тэнцүү, Бага сайн, Илүү сайн
 - *Spec type*: Үзүүлэлтийн төрлийг сонгож өгнө. Үүнд: *Required* - Шаардлагатай, *Recommend* – Зөвлөж байгаа, *Optional* - Дурын, *Static* - Байнгын
 - *Хайж болох талбар*: тохируулах
 - *Type*: үзүүлэлтийн утгын төрлийг сонгоно. Үүнд: *Integer* - Бүхэл тоон утгууд, *String* - Тэмдэгт мөр утга, *Boolean* – True эсвэл False утга, *Аравтын тоо* - Хязгаарын утга, *Percent* - Хувь, *Selection* - Сонголтоор, *Range* - Мужийн утга, *Өнгө* - өнгөний кодоос сонгох, *Огноо*
- Тухайн барааны техникийн үзүүлэлтийг бүлэглэх шаардлагатай бол **Бүлэглэх** товч дээр дарж бүлгийн нэрээ оруулна.



Зураг 11. Тухайн техникийн үзүүлэлтийг өөрчлөх болон үзүүлэлтийн төрөл өөрчилж хадгалах

- **Хиймэл оюун ухаан** товч нь танд техникийн үзүүлэлтийг санал болгох бөгөөд суралцаж буй эхний үедээ оновчтойгоор санал болгож чадахгүй байх магадлалтай. Санал болгосон үзүүлэлтийг өөрийн  техникийн үзүүлэлт рүү сонгож авах товчийг дарж оруулна.
- Ноорог төлөвтэй байгаа барааны хүсэлтийг оруулсан хэрэглэгч өөрөө устгаж болно.



Төлөв	Нэр	Бренд	Загвар	Бүтэц	Үүсгэсэн	Approval state
<input checked="" type="checkbox"/>	Ноорог	Түвшний хэмжүүр	Siemens	SITRANS LR 560	Холбоо, мэдээллийн техноло...	П.Нацагдорж
<input type="checkbox"/>	Ноорог	Эксцентрикийн температуры...	C-temp	RTD	Холбоо, мэдээллийн техноло...	П.Нацагдорж
<input type="checkbox"/>	Ноорог	Бөмбөлгөн хаалт	FESTO	QH-1/2-9543	Холбоо, мэдээллийн техноло...	П.Нацагдорж


Зураг 12. Техникийн үзүүлэлт нэмэх болон засах цонх

Өөрийн оруулсан барааны хүсэлтийн жагсаалтаас сонгохоор дараах товчнууд гарч ирэх бөгөөд **Action** товч дээр дарахад устгах команд гарч ирээд түүгээр устгана.




Зураг 13. Нэг барааны хүсэлтийг сонгох үед гарч ирэх товчнууд

- Шинэ бараа бүртгэх хүсэлтийг оруулж, засварлаж дууссаны дараа захиалагч бүтцийн нэгжийн хэрэглэгч **Эхлэх** товчийг дарж шинэ бараа бүртгэх хүсэлтийг чиглэл хариуцсан бүтцийн нэгж рүү илгээх бөгөөд тухайн хүсэлт дараагийн төлөв болох **Хүлээгдэж байна** төлөвт шилжинэ.



Зураг 14. Шинэ бараа бүртгэх хүсэлт оруулсны дараа Эхлүүлэх товч


- “**Эхлэх**” товч дарахад дараа Мэдээллийн цонх гарсан тохиолдолд тухайн 60131416 ангилалд чиглэл хариуцсан бүтцийн нэгж байхгүй тухай мэдэгдэл юм. Иймд хэрэглэгч та сургалт дэмжлэгийн багийн мэргэжилтэнтэй холбогдон ангиллыг нэмж бүртгүүлнэ.



Зураг 15. Мэдэгдлийн анхааруулах цонх

- Шинэ бараа бүртгэх хүсэлтийг эхлүүлсний дараа Чиглэл хариуцсан бүтцийн нэгж болон Үйлдвэрлэл, техникийн хэлтсийн мэргэжилтнээс сайжруулах зөвлөмж, тайлбарыг бичиж буцаах боломжтой. Буцаагдсан бараа дараах байдлаар харагдаж


бөгөөд Ноорог төлөвтэй байх бөгөөд буцаасан чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн мэргэжилтний нэр харагдана.



Төлөв	Нэр	Бренд	Загвар	Бүтцийн нэгж	Approval state
Ноорог	Хий авагчтай хаалт wika IV20 1 wika		IV20 1/2 NPT male / 1/2 NPT female	Холбоо, мэдээллийн	
Ноорог	Пневматик valves FESTO Quarte FESTO	FESTO	DFPD	Холбоо, мэдээллийн	Буцаасан Ц.Чинзориг
Ноорог	Металл илрүүлэгч ERIEZ QM3C ERIEZ	ERIEZ	QM3000	Холбоо, мэдээллийн	П.Нацагдорж дахин эхлүүлээ
Ноорог	Бөмбөлгөн хаалт	FESTO	QH-1/2-9543	Холбоо, мэдээллийн	
Ноорог	Эксцентрикийн температурын C-temp		RTD	Холбоо, мэдээллийн	П.Нацагдорж дахин эхлүүлээ
Ноорог	Хий авагчтай хаалт wika	wika	IV20 G 1/2 male / G 1/2 female	Холбоо, мэдээллийн	
Ноорог	Түвшний хэмжүүр	Siemens	SITRANS LR 560	Холбоо, мэдээллийн	Буцаасан Ц.Чинзориг
Ноорог	Хийн актуатор Bray Series 92/9 Bray		Series 92/93	Холбоо, мэдээллийн	

Зураг 16. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн төлөв харагдах хэсэг


Тухайн буцаасан бараа руу дарж ороход буцаасан тайлбар доор нь харагдана.



Зураг 17. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн буцаасан тайлбар


Хэрэглэгч та мэргэжилтний тайлбарын дагуу засвараа оруулаад дахин эхлүүлэх товч дарж эхлүүлнэ.

- Тус хүсэлтийг үүсгэсэн захиалагч бүтцийн нэгжийн хэрэглэгч өөрийн зүгээс дахин боловсруулалт хийн өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд **Дахин эхлүүлэх** товчийг дарж, шинэ бараа бүртгэх хүсэлтийг **Ноорог** төлөвт шилжүүлж болно.



Зураг 18. Хяналтын шатанд илгээгдсэн төлөв

- Баталгаажуулалт:** Барааны хүсэлт нь чиглэл хариуцсан бүтцийн нэгж болон Үйлдвэрлэл, техникийн хэлтэс хянаж, баталгаажуулалт хийсний дараа барааны каталогт автоматаар орно.



Tier	Name	Requested ...	Status	Todo By	Done By	Validation Date	Comments
1	Чиглэл хариуцсан...	П.Нацагдорж	Approved	Б.Гансүх, М.Мө...	Ю.Даваадо...	2024-05-06 16:00...	
2	Үйлдвэрлэл, тех...	П.Нацагдорж	Pending	Б.Пүрэвдорж, Г...			

Зураг 19. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн баталгаажуулалтын мэдээлэл харах цонх

12. Шинэ бараа бүртгэх хүсэлтүүд жагсаалт хэлбэрээр харагдах бөгөөд тухайн шинээр бүртгэх барааны явцын төлөвийг харж болно.

<input type="checkbox"/>	Төлөв	Нэр	Бренд	Модел	Бүтцийн нэгж	Үүсгэсэн	Approval state
<input type="checkbox"/>	Зөвшөөрсөн	Цахилгаан тэжээл баригч...	Eaton	INDGW-M2	Холбоо, мэдээллийн техн...	П.Нацагдор...	Баталгаажуулсан Б.Мен...
<input type="checkbox"/>	Ноорог	Linear actuator FESTO DFPI	FESTO	DFPI-2(INDGW-M2) E-NB...	Холбоо, мэдээллийн техн...	П.Нацагдор...	
<input type="checkbox"/>	Хүлээгдэж бай...	Агаарын урсгал хэмжигч ...	Sierra	SteelMass 640s	Холбоо, мэдээллийн техн...	П.Нацагдор...	Started by П.Нацагдорж
<input type="checkbox"/>	Хүлээгдэж бай...	24VDC цахилгаан тэжээл...	Phoenix Conta...	QUINT-PS/1AC/24DC/20	Холбоо, мэдээллийн техн...	П.Нацагдор...	Started by П.Нацагдорж

Зураг 20. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн явцын төлөв

13. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтаас хайлтын багажийг ашиглан өөрт шаардлагатай шүүлт, бүлэглэлийг хийн ашиглах боломжтой бөгөөд өөрийн үүсгэсэн шүүлт, бүлэглэлд нэр өгч хадгалан тогтмол ашиглаж болно.

Зураг 21. Чиглэл харцуцсан бүтцийн нэгжийн төлөв харагдах хэсэг

14. Бэлэн болсон техникийн үзүүлэлтээ харах бол барааны нэрийн ард байрлах араа дүрсийг хулганаар дарж бүтээгдэхүүний тайланг хүсэх-ийг сонгож харах боломжтой.

Зураг 23. Оруулсан техникийн үзүүлэлт харах.

15. Техникийн үзүүлэлтээ хэвлэх бол барааны хүсэлтийн жагсаалтаас барааны нэрийн ард байрлах араа дүрсийг хулганаар дарж **Бүтээгдэхүүний тайланг хүсэх**-ийг сонгож ороход хэвлэх товч гарч ирнэ.

Дд	Үзүүлэлтийн нэр	Хэмжээ нэгж	Үзүүлэлт	Чиглэл
1	Хууцлага хэлтүүрэм чамар		Дэмжлэгтэй оптик	Баталгаажуулсан
2	Хөсбөлгөөм төрөл		USB хүлгэм алагч, Bluetooth 5.3, Logitech Unifying USB Receiver	Баталгаажуулсан
3	Гарцаттуй ажиллах хугацаа	сар	4	Баталгаажуулсан
4	Гүйлгээг зууруй		Precision Scroll Wheel	Баталгаажуулсан
5	Ажиллах төлөвийн хэлбэр		Эргономик	Баталгаажуулсан
6	Шарилцажиган төлөвийн төрөл		Tailor	Баталгаажуулсан
7	Хөсбөлгөөм боловсруулж төлөвийн төрөл		3	Баталгаажуулсан
8	Дэмжлэг үйлдлийн системүүд		Windows, Linux, macOS, Chrome OS	Баталгаажуулсан
9	Баталгаажуулсан төлөвийн төрөл	мл/ц	180	Баталгаажуулсан
10	Баталгаажуулсан төрөл		Li-Polymer	Баталгаажуулсан
11	Баталгаажуулсан хугацаа	жиш	1	Баталгаажуулсан
12	Босоо хөсбөлгөөмийн төлөвийн төрөл	цэгцлэлт	4000	Баталгаажуулсан
13	Баталгаажуулсан төлөвийн төрөл	төгс	true	Баталгаажуулсан

Зураг 24. Техникийн үзүүлэлт харах, хэвлэх.

16. Барааны хүсэлтийн жагсаалтын баруун дээд өнцөгт байрлах тэмдэглэгээг дарж **Баталгаажуулалт** гэсэн сонголтыг хийснээр шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтад тухайн барааны хүсэлтийг батлахаар хүлээгдэж буй бүтцийн нэгжийн мэдээллийг агуулсан багана нэмэгдэнэ.

Модел	Бүтцийн нэгж	Үүсгэс...	Approval state	Баталгаажуулалт
Carlson VX7	Холбоо, мэдээллийн технол...	Д.Энхбаяр	Баталгаажуулсан Ю.Даваад...	Батлах: <input checked="" type="checkbox"/> Баталгаажуулалт
Pitram	Холбоо, мэдээллийн технол...	Д.Энхбаяр	Started by Д.Энхбаяр	Батлах: Чиглэл хариуцсан б...
nterVolt SPCI242410G2	Холбоо, мэдээллийн технол...	Д.Энхбаяр	Буцаасан Ю.Даваадорж	
DRAN 120-24	Холбоо, мэдээллийн технол...	Д.Энхбаяр	Буцаасан Ю.Даваадорж	

Зураг 25. Шинэ бараа бүртгэх хүсэлтийн жагсаалтад баталгаажуулалтын багана нэмэх

17. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжид хянуулахаар илгээсэн барааны хүсэлт нь барааны жагсаалтаас **Хүлээгдэж байна** төлөвтэй харагдана.

Төлөв	Нэр	Бренд	Модел	Бүтцийн нэгж	Үүсгэсэн	Approval state
Хүлээгдэж байна	Тоон телефон апп...	Unify	Openstage 15T	Холбоо, мэдээлли...	М.Мөнхбаяр	
Ноорог	Кабель RVVP 3x0.3	Кабель RVVP 3x0.5	RVVP 3x2x0.5	Холбоо, мэдээлли...	Д.Очирбат	Restarted by Adm...
Чиглэл хариуцса...	Цахилгаан тэжээл ...	Eaton	INDGW-M2	Холбоо, мэдээлли...	П.Нацагдорж	
Ноорог	Linear actuator FES...	FESTO	DFPI-200-250-ND2...	Холбоо, мэдээлли...	П.Нацагдорж	

Зураг 26. Чиглэл хариуцсан бүтцийн нэгжийн хяналтаар хүлээгдэж буй төлөв

- Чиглэл хариуцсан бүтцийн нэгж нь хянаж, зөвшөөрөөд Үйлдвэрлэл, техникийн хэлтсийн хяналтад шилжүүлэх үед тухайн шинэ бараа бүртгэх хүсэлт нь **Хянасан** төлөвт шилжинэ.

Дараалал	Нэр	Хүсэлт гаргас...	Status	Батлах	Done By	Баталсан огноо	Comments
1	Чиглэл хариуцсан...	П.Нацагдорж	Баталсан	Б.Гансүх, М.Мөнх...	Ю.Даваадо...	2024-05-06 16:01:47	
2	Үйлдвэрлэл, техни...	П.Нацагдорж	Хүлээгдэж байна	Б.Пүрэвдорж, Г.Зо...			

Зураг 27. Шинэ бараа бүртгэх хүсэлтийг чиглэл хариуцсан бүтцийн нэгж хянасан төлөв

- Үйлдвэрлэл, техникийн хэлтэс тухайн шинэ бараа бүртгэх хүсэлтийг хянаж, зөвшөөрсний дараа **Зөвшөөрсөн** төлөвт шилжиж тухайн барааны хүсэлт баталгаажиж каталогт бүртгэгдэнэ.


Дараалал	Нэр	Хүсэлт гаргас...	Status	Батлах	Done By	Баталсан огноо	Comments
1	Чиглэл хариуцсан бү...	П.Нацагдорж	Баталс...	Б.Гансүх, М.Мөнхбаат...	Ю.Даваадо...	2024-05-06 16:01:47	
2	Үйлдвэрлэл, техни...	П.Нацагдорж	Баталс...	Б.Пүрэвдорж, Г.Зориг...	Б.Мөнхнасан	2024-05-08 10:50:13	

Зураг 28. Шинэ бараа бүртгэх хүсэлт 2 шатны баталгаажуулалт хийгдсэн төлөв

Худалдан авалт	Хүсэлт	Захиалгууд	Бараа	Лавлах
Шинэ	Бараа		Шинэ бараа бүртгэх хүсэлт Бараа	

<p>UNSPSC АНГИЛАЛ</p> <p>A - Raw Materials, Chemicals, Paper, Fuel (Түүхий эд, химийн бодис, цаас, түлш) [Сырье, химикаты, бумага, топливо]</p>	<p>Цахилгаан тэжээл баригчийн сүлжээний карт Eaton INDGW-M2</p> <p>Eaton</p> <p>Үнэ: 1'700'000.00 ₮</p> <p>Хөрөнгийн төрөл Эргэлтийн хөрөнгө</p>
---	--

Зураг 29. Барааны каталог

 **Мэдээлэл:** Мөн **demo-odoo.erdnetmc.mn** домэйн хаягаар орж олон улсад хэрэглэгдэж буй UNSPSC ангиллыг ашиглан үүсгэсэн барааны каталог, барааны техникийн үзүүлэлтийн жишээг харах боломжтой.

Сургалт, дэмжлэгийн баг